

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Тохилог хараа” ААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/007/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум 2026 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn
	Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“ТОХИЛОГ ХАРАА” ААТҮГ-ЫН
ДАРГА Н.ЦЭРЭНТОГТОХ ТАНАА

2026.03.15 № СЭА-2026/007/НА-СТА-ОНОВГ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Тохилог хараа” ААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Тохилог хараа” ААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн “Үндсэн хөрөнгө балансаас баланст шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай” 49 дүгээр тогтоолоор аймгийн ЗДТГ-аас 275,500.0 мянган төгрөгийн Хово ачааны өөрөө буулгагч тээврийн хэрэгсэл, сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 33,000.0 мянган төгрөгийн хог хаягдал шатаах зуух, 22,950.0 мянган төгрөгийн давс цацагч төхөөрөмж, 111,500.0 мянган төгрөгийн хог нягтруулан тээвэрлэгч машиныг үнэ төлбөргүйгээр тус тус хүлээн авч, бүртгэл тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

4326050317

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 202501 дугаартай “Орон нутгийн өмчийн түрээсийн гэрээ”-ний дагуу Мандал Хишиг Хайрхан ОНӨААТҮГ-ын 418,596.4 мянган төгрөгийн балансын үнэтэй, 44 нэр төрлийн хөрөнгийг мах бэлтгэлийн газрын үйл ажиллагаа эрхлэх зориулалтаар тус газарт ашиглуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

“Тохилог хараа” ААТҮГ нь 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, Мандал сумын ИТХ-ын 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор “Хангалттай” гэж дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	180,430.28	3,057,853.75
1.1.02	Дансны авлага	14,185,808.00	30,933,190.00
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	950,154.00	773,066.20
1.1.04	Бусад авлага	-	661,077.00
1.1.06	Бараа материал	1,773,490.00	79,712,739.20
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	700,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	17,089,882.28	115,837,926.15
1.2.01	Үндсэн хөрөнгө	482,723,164.80	670,742,623.07
1.2.02	Биет бус хөрөнгө	16,897,569,861.67	14,683,066,550.19
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	17,380,293,026.47	15,353,809,173.26
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	17,397,382,908.75	15,469,647,099.41
2.1.1.01	Дансны өглөг	4,226,670.88	14,470,725.00
2.1.1.02	Цалингийн өглөг	1,487,403.09	1,301,854.17
2.1.1.03	Татварын өр	16,785,229.52	4,939,738.35
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	22,499,303.49	20,712,317.52
2.2	Өр төлбөрийн нийт дүн	22,499,303.49	20,712,317.52
2.3.02	- хувийн	1,014,238,197.67	1,014,238,197.67
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,547,846.88	1,547,846.88
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	568,726,481.01	1,011,676,481.01
2.3.09	Хуримтлагдсан ашиг	15,790,371,079.70	13,421,472,256.33
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(2,356,092,219.57)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	15,790,371,079.70	15,777,564,475.90
2.3.11	Эздийн өмчийн дүн	17,374,883,605.26	15,448,934,781.89
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	17,397,382,908.75	15,469,647,099.41

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,248,659,251.40	1,822,325,649.26
02	Борлуулалтын өртөг	1,463,406,895.72	1,794,360,630.08
03	Нийт ашиг(алдагдал)	(214,747,644.32)	27,965,019.18
08	Бусад орлого	2,367,821.66	705,000.00
08.1	Орлогын дүн	2,367,821.66	705,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,293,913,753.37	2,378,577,715.02
12	Бусад зардал	3,329,500.00	6,171,670.00
12.1	Зардлын дүн	2,297,243,253.37	2,384,749,385.02
17	Бусад ашиг (алдагдал)	(9,000.00)	(12,853.73)
17.1	Олз, гарзын дүн	(9,000.00)	(12,853.73)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(2,509,632,076.03)	(2,356,092,219.57)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(2,509,632,076.03)	(2,356,092,219.57)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(2,509,632,076.03)	(2,356,092,219.57)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,014,238,197.67	1,547,846.88	18,300,003,155.73	19,315,789,200.28
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(2,509,632,076.03)	(2,509,632,076.03)
09	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	1,014,238,197.67	1,547,846.88	15,790,371,079.70	16,806,157,124.25
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(12,806,603.80)	(12,806,603.80)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(2,356,092,219.57)	(2,356,092,219.57)
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	1,014,238,197.67	1,547,846.88	13,421,472,256.33	14,437,258,300.88

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,417,021,810.40	2,019,161,386.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	287,697,268.40	350,847,180.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	600,000.00	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,466,942.00	1,316,656.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,126,948,600.00	1,660,692,550.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	309,000.00	6,305,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,413,833,796.84	2,015,581,499.79
1.2.1	Ажиллагчдад төлсөн	632,648,072.43	781,714,227.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	179,497,443.84	202,722,772.82
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	48,010,030.00	210,293,260.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	107,336,310.67	147,937,664.10
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	194,540,925.49	313,122,789.84
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	58,002,837.74	101,080,167.26
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,061,659.00	1,544,130.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	192,736,517.67	257,166,488.77
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,188,013.56	3,579,886.21
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	50,106.66	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	50,106.66	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,169,900.00	891,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,169,900.00	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	891,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,119,793.34)	(891,000.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	68,220.22	2,688,886.21
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	67,210.06	180,430.28
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	180,430.28	3,057,853.75

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого	1,718,200.00	1,822,325.65	(104,125.65)	106.06
	Үндсэн үйл ажиллагаанаас	186,000.00	227,142.42	(41,142.42)	122.12
	Туслах үйл ажиллагаанаас	45,000.00	140,940.68	(95,940.68)	313.20
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,487,200.00	1,454,242.55	32,957.45	97.78
2	Нийт зардал	1,705,751.10	4,179,122.87	(2,473,371.77)	245.00
	Үндсэн цалин	904,923.60	953,302.08	(48,378.48)	105.35
	Ажил олгогчоос төлөх НДШ	122,164.69	120,459.32	1,705.37	98.60
	Гэрэл цахилгаан	324,115.89	254,566.99	69,548.90	78.54
	Түлш халаалт	18,046.40	17,538.15	508.25	97.18
	Цэвэр бохир ус	936.00	7,149.14	(6,213.14)	763.80
	Бичиг хэрэг	4,129.50	3,303.48	826.02	80.00
	Тээвэр шатахуун	193,530.68	222,625.07	(29,094.39)	115.03
	Шуудан холбоо	843.48	194.83	648.65	23.10
	Дотоод албан томилолт	1,100.00	300.00	800.00	27.27
	Сэлбэг техник хэрэгсэл	65,333.06	65,333.06	-	100.00
	Эд хогшил авах /үндсэн хөрөнгө/	3,100.00	3,100.00	-	100.00
	Хөдөлмөр хамгаалал	21,452.50	19,412.50	2,040.00	90.49
	Урсгал засвар	30,138.00	24,157.39	5,980.61	80.16
	Ариутгал халдваргүйжилт, хор саармагжуулалт	2,040.00	2,040.00	-	100.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	5,350.30	5,350.30	-	100.00
	Хөрөнгө оруулалт	8,547.00	8,693.92	(146.92)	101.72
3	Үндсэн хөрөнгийн элэгдэл	-	2,471,596.65	(2,471,596.65)	
4	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	12,448.90	(2,356,797.22)	2,369,246.12	
5	Бусад орлого	-	705.00	(705.00)	
6	Орлогын албан татвар	1,244.89	-	1,244.89	
7	Татварын дараах ашиг, алдагдал	11,204.01	(2,356,092.22)	2,367,296.23	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **13,747.2** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **360.0** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **13,387.2** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **13,747.2** мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс **9,225.2** мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

1. Төлбөрийн акт

1. Тушаал шийдвэргүйгээр дарга Н.Цэрэнтогтох-д шагналт цалинд **360.0** мянган төгрөгийг тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”*, 20 дугаар зүйлийн 20.2 дахь *“Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ.”* 20.2.5 дахь *“ ... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа, ашиглах боломжгүй актлах нийт **47** нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, дахин үнэлэх, актлах саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь *“... хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгахад дараах журмыг баримтална: 2/ эд хөрөнгө ... засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, 3/ “засаж сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх *“Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана: 4.2.1.10: Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”* гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

2. ИТХ-аар батлагдсан орон тоог хэтрүүлээгүй боловч цалингийн санг **1,599.6** мянган төгрөгөөр хэтрүүлэн, цалин тооцож олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д *“Захирал дараах эрх, үүрэгтэй: 4: үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас*

тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох гэсэн заалт болон Мандал сумын ИТХ-ын 2025 оны 01 дүгээр сарын 30-ын өдрийн 21 дүгээр “Тохилог хараа” ААТҮГ-ын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн тухай” тогтоолыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан цалингийн санд багтаан цалин хөлсийг тооцож олгох ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3. Анхан шатны баримтын бүрдэлгүй, спидометрийн заалт, явсан км, нормыг тэмдэглээгүй зэргээр жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, жолооч хүлээн авсан шатахууны хэмжээгээр зарцуулалтыг гаргасан, нягтлан бодогч тухай бүр тооцоог хийж, хэтрэлт хэмнэлтийг гаргалгүйгээр **11,787.6** мянган төгрөгийн шатахууны тайланг бэлтгэн, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*”, 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	1	-			1	-						
Батлагдсан цалингийн санг хэтрүүлэн цалин тооцож олгосон.	1	1,599.6			1	1,599.6						
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ гүйцэтгэсэн	1	11,787.6			1	11,787.6						
Дүн	4	13,747.2	1	360.0	3	13,387.2						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
2 мэдээллийг огт мэдээлээгүй, 4 төрлийн 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	-			1	-		